



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 20 өдөр

Дугаар 95

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Засгийн газрын 2022 оны 204 дүгээр тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай" 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, "Мэдээ тайлангийн маягт батлах тухай" 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалт, 2023 оны 467 дугаар тогтоолын 2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шүүх шинжилгээний ерөнхий газрын харьяа байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжгүй болсон, нийт 68,395,333.48 (жаран найман сая гурван зуун ерэн таван мянга гурван зуун гучин гурван төгрөг дөчин найман мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий 5 автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар, Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ж.Буянбат болон тогтоолд заасан байгууллагын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;


2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, удирдлага, зохицуулалтын цахим систем"-д бүртгэх;

2.4. Автомашиныг худалдсаны дараа улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх;

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2025 оны 22 дугаар сарын 20-ны өдрийн
95 дугаар тогтоолын хавсралт

ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭЛТЭЙ, НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГЫН ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ АВТОМАШИНЫ
ЖАГСААЛТ

Д/д	Автомашины нэр, марк	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ, нийт үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)
1.Төв аймаг дахь Шүүхийн шинжилгээний хэлтэс					
1	Ландкрузер-80, 46-87 ТӨА	1993/2008	307322	22,512,000.00	7,000,000.00
	Дүн			22,512,000.00	7,000,000.00
2.Дархан-Уул аймаг дахь Бүсийн шүүх шинжилгээний төв					
	Хьюндай старекс, 04-22 ДАР	2007/2013	311834	4,500,000.00	3,500,000.00
	Дүн			4,500,000.00	3,500,000.00
3.Өвөрхангай аймаг дахь бүсийн Шүүх шинжилгээний төв					
3	Тоёотоландкрузер-100, 01-11 ӨВӨ	2004/2011	245121	20,333,333.48	10,000,000.00
	Дүн			20,333,333.48	10,000,000.00
4.Орхон аймаг дахь Шүүх шинжилгээний хэлтэс					
4	Хьюндай старекс, 00-94 ОРО	2006/2012	140688	17,500,000.00	3,500,000.00
	Дүн			17,500,000.00	3,500,000.00
5.Дундговь аймаг дахь Шүүх шинжилгээний хэлтэс					
5	Соната-5, 04-30 УБЗ	2002/2002	155000	3,550,000.00	3,500,000.00
	Дүн			3,550,000.00	3,500,000.00
5	Нийт дүн			68,395,333.48 (жаран найман сая гурван зуун ерэн таван мянга гурван зуун гучин гурван төгрөг дөчин найман мөнгө)	27,500,000.00 (хорин долоон сая таван зуун мянга)